



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/67

Ховд

Хурдан морины уралдааны талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглосугай.


2. Хурдан морь унадаг уралдаанч хүүхэд, багачуудад үүсч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийт, эцэг эх, уяачдад мэдээлж, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймаг, сумдын Морин спорт, уяачдын холбооны тэргүүн нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Мөнхболд), Мэргэжлийн хяналтын газар (П.Эрдэнэчулуун), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Баяртуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/148 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



• 8400 01 0375
D/Zah-A/67-Bo